# УЛААНБААТАР ХОТЫН
# ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2025 оны 10 сарын 17 өдөр Дугаар А/154 Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3.1, 24.3.3 дахь заалт, 24.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Монгол улсын Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь хэсэг, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны "Нийслэлийн 2025 оны төсөв батлах тухай" 25/113 дугаар тогтоол, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байрлах Гэрээ төлбөрийн зөрчилтэй, зөвшөөрөлгүй байрлуулсан, стандартын шаардлага хангаагүй гадна зар сурталчилгаа, реклам мэдээлэл, хаяг хаягийн байгууламжуудыг албадан буулгах ажлын төсөл арга хэмжээг зохион байгуулах, ажлын задаргааг хавсралт ёсоор баталсугай.

2.Тушаалын хавсралтаар батлагдсан төсөл арга хэмжээг холбогдох хууль, тогтоомжийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, ажиллахыг (Б.Даваабаяр)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын 1 дүгээр заалтад тусгагдсан ажилд шаардагдах 100,000,000 (Нэг зуун сая) төгрөгийг Хот тохижилтын бусад зардлаас гаргаж санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч (Б.Халиун)-д зөвшөөрсүгэй.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт үнэлгээний газар (Ц.Рэгзэдмаа)-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Г.БАТЗОРИГ

D:\Албан бичиг\doc 2025\Тушаал-2025.docx

1725010606

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн
А/154 тушаалын хавсралт

# ГЭРЭЭ ТӨЛБӨРИЙН ЗӨРЧИЛТЭЙ, ЗӨВШӨӨРӨЛГҮЙ БАЙРЛУУЛСАН, СТАНДАРТЫН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ГАДНА ЗАР СУРТАЛЧИЛГАА, РЕКЛАМ, ХАЯГ, ХАЯГИЙН БАЙГУУЛАМЖУУДЫГ АЛБАДАН БУУЛГАХ АЖЛЫН ЗАРДАЛ

| № | Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Хугацаа | | Төсөвт өртөг | Санхүүжих дүн (сая.төг) |
|---|---|---|---|---|---|
| | | Эхлэх | Дуусах | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Гэрээ төлбөрийн зөрчилтэй, зөвшөөрөлгүй байрлуулсан, стандартын шаардлага хангаагүй гадна зар сурталчилгаа, реклам мэдээлэл, хаяг хаягийн байгууламжуудыг албадан буулгах ажлын зардал | 2025 | 2025 | 100,000,000 | 100,000,000 |
| Нийт | | | | **100,000,000** | **100,000,000** |

D:\Албан бичиг ... 2025 ... Тушаал.docx 1725010580